

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2015 ОНЫ I УЛИРЛЫН НЭГДСЭН ТОЙМ /Банкнаас бусад салбар/

БОЛОВСРУУЛСАН:
ЗЗХГ-ЫН НБТХ-ИЙН ДАРГА А.АВИР
АХЛАХ РЕФЕРЕНТ Ц.ЦЭРЭНТОГТОХ
РЕФЕРЕНТ Н.ЭНХБААТАР
МЭРГЭЖИЛТЭН Н.НАРАНТУЯА

УЛААНБААТАР 2015

Агуулга

I БҮЛЭГ: МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ОРЧИН	5
Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
Банкны салбар:	5
Улсын төсөв:	7
Гадаад худалдаа, төлбөрийн баланс:	7
Гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад өрийн хэмжээ:	7
Инфляцийн түвшин:	7
II БҮЛЭГ: ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ	9
2.1. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн болон үндсэн үзүүлэлтүүд:	9
Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар:	9
Хувьцааны арилжаа:	9
Засгийн газрын үнэт цаасны арилжаа:	10
Топ-20 индекс болон MSE ALL индексийн үзүүлэлт:	10
2.2. Үнэт цаас гаргагчид болон хөрөнгө оруулагчдын бүтэц:	11
Хөрөнгө оруулагчдын бүтэц:	12
2.3. Мэргэжлийн зуучлагч байгууллага:	13
2.4. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц, зохицуулалт:	14
III БҮЛЭГ: ДААТГАЛЫН САЛБАРЫН ТОЙМ	16
3.1. Даатгалын салбарын өнөөгийн байдал:	16
3.2. Салбарын статистик үзүүлэлтүүд:	17
3.3. Даатгалын салбарын бүтээгдэхүүн үйлчилгээ:	19
3.4. Даатгалын салбарын хөгжлийн үзүүлэлтүүд:	20
Даатгалын гүнзгийрэлт:	20
Даатгалын нягтрал:	20
Зохистой харьцааны үзүүлэлтүүд:	21
IV БҮЛЭГ: БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ	23
4.1. Бичил санхүүгийн салбарын өнөөгийн байдал:	23
4.2. Банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид:	24
4.3. Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн үзүүлэлт:	25
Активын үзүүлэлтүүд:	25
Зээлийн үзүүлэлт:	27
4.4. Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны үзүүлэлт:	27
4.5. Банк бус санхүүгийн байгууллагын зохистой харьцааны үзүүлэлт	29
4.6. Хадгаламж зээлийн хоршооны өнөөгийн байдал:	29
4.7. Хадгаламж зээлийн хоршоод, тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүд:	30

Хадгаламж зээлийн хоршоодын зээлийн үзүүлэлтүүд:.....	31
Хадгаламж зээлийн хоршоодын хадгаламжийн үзүүлэлтүүд:.....	32
<i>V БҮЛЭГ:ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ.....</i>	34
5.1. Үнэт цаасны зах зээл:	34
5.2. Даатгалын салбар:	34
5.3. Бичил санхүүгийн салбар:.....	35
<i>VI БҮЛЭГ: ҮНЭТ ЦААС, ДААТГАЛ, БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРТ ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ.....</i>	36
6.1. Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр:	36
6.2. Даатгалын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр:	36
6.3. Нэгдсэн бодлого, зохицуулалтын чиглэлээр:.....	37

ХҮСНЭГТҮҮД

- Хүснэгт-1 Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар
- Хүснэгт-2 Үнэт цаас гаргагч компанийн хэлбэр
- Хүснэгт-3 Хөрөнгө оруулагчдын бүтэц
- Хүснэгт-4 Мэргэжлийн оролцогч
- Хүснэгт-5 Даатгалын салбарын үйл ажиллагааны үзүүлэлт
- Хүснэгт-6 Нөхөн төлбөрийн хэмжээ
- Хүснэгт-7 Хураамжийн орлого
- Хүснэгт-8 Даатгалын нэвтрэлт
- Хүснэгт-9 Даатгалын нягтрал
- Хүснэгт-10 Даатгалын салбарын зохистой харьцаа
- Хүснэгт-11 Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны төрөл
- Хүснэгт-12 ББСБ-ын богино хугацаат хөрөнгө оруулалт
- Хүснэгт-13 Банк бус санхүүгийн байгууллагын бүтэц
- Хүснэгт-14 Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа
- Хүснэгт-15 ББСБ-ын зохистой харьцаа
- Хүснэгт-16 Хадгаламж зээлийн хоршоодын санхүүгийн үндсэн үзүүлэлт

ГРАФИКУУД

- График-1 Хувьцааны арилжаа
- График-2 Арилжааны хувь
- График-3 Даатгалын нэвтрэлт
- График-4 Даатгалын нягтрал
- График-5 Банк бус санхүүгийн байгууллагын актив
- График-6 Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын өсөлт
- График-7 Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын бүтэц
- График-8 Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн багц
- График-9 Хадгаламж зээлийн хоршоодын нийт актив
- График-10 Хадгаламж зээлийн хоршоодын нийт активын өсөлт
- График-11 Хадгаламж зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар
- График-12 Хадгаламж зээлийн хоршоодын ашигт ажиллагаа
- График-13 Хадгаламж зээлийн хоршоодын хадгаламжийн өөрчлөлт

ЗУРАГ

- Зураг-1 Өнөөгийн үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц
- Зураг-2 Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн цаашдын хандлага
- Зураг-3 Хадгаламж зээлийн хоршоодын байршил

I БҮЛЭГ:МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ОРЧИН

Манай улсын макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлаас харахад дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ханш суларснаас үүдэн экспортын орлогын хэмжээ буурч, гадаад валюттай харьцах төгрөгийн ханш суларсан нь эргээд эдийн засгийн өсөлтийг удаашруулж байна.

Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ цэвэр дүнгээр 111 сая ам.долларт хүрч, 2014 оны 1 дүгээр улирлаас даруй 391 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байгаа ба гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан нь эргээд татварын орлогын хэмжээг бууруулж, төсвийн тэлэх бодлогыг цаашид баримтлах нөхцөлд төсвийн алдагдал өсөх хандлагатай.

Монголбанкнаас төсвийн тэлэх бодлоготой холбогдуулан мөнгөний хатуу бодлогыг сүүлийн жилүүдэд барьж ирсэн нь хувийн салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулах, төсвийн хөрөнгө оруулалтаас хэт хамааралтай байдлыг бий болгож байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэн үзвэл санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуур бүхий, урт хугацааны санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгох, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрэлт, нийлүүлэлт, дэд бүтцийн уялдаа холбоонд тулгуурлан эрчимжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, олон улсын болон бүс нутгийн интеграцид нэгдэх шаардлага бий болжээ.

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцоход 2015 оны эхний улиралд 2854.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 119.6 тэрбум төгрөг буюу 4.4 хувиар өссөн байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг оны үнээр тооцоход 2015 оны эхний улиралд 4525.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 390.8 тэрбум төгрөг буюу 9.4 хувиар тус тус өсөлттэй байна. Дээрх өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 9.2, аж үйлдвэр, барилгын салбар 13.1, үйлчилгээний салбар 3.3 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ.

Олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ ханш өссөнтэй холбоотойгоор Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011-2012 онд огцом нэмэгдсэн. Үүнээс улбаалан, хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудын хувьцааны эрэлт өссөн нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, арилжааны хэмжээг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болсон билээ. Гэвч 2013 онд олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ ханш буурсан, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин тодорхойгүй байсан зэрэг шалтгааны улмаас гадаадын шууд хөрөнгө оруулалт багассан.

Макро эдийн засгийн хүрээнд 2006-2014 онуудад дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт 17.0-7.8 хувийн хооронд байсан хэдий ч орлогын хуваарилалт оновчтой бус байгаагаас иргэдийн орлогын болон амьжиргааны түвшинтэй хамааралгүй, эдийн засгийг хөдөлгөгч нийгмийн хүчтэй дундаж давхарга бий болж чадаагүй зэрэг нь үнэт цаасны зах зээлийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Банкны салбар: Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны 4 дүгээр сарын эцэст 9.7 их наяд төгрөг болж, өмнөх сарынхаас 198.7 тэрбум төгрөг буюу 2.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 498.3 тэрбум төгрөг буюу 4.9 хувиар буурчээ. Арилжааны банкны зээлийн үлдэгдэл 2015 оны 1 дүгээр улирлын байдлаар 12.3 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны 4 дүгээр сарын эцэст 12.3 их наяд төгрөг болж, өмнөх сарынхаас 26.3 тэрбум төгрөг буюу 0.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 559.0 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар өсчээ.

Тайлант хугацаанд нийт хадгаламжийн үлдэгдэл 8.45 их наяд төгрөгт хүрч, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 12.3 хувь байгаа нь иргэд, аж ахуйн нэгжүүд хуримтлалаа хөрөнгө оруулалтад бус банкны хадгаламжид байршуулах, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээ хөрөнгийн зах зээлээс босгохоос илүүтэйгээр банкны богино хугацаат санхүүжилтээр нөхөх хандлага давамгайлж байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны 4 дүгээр сарын эцэст 587.8 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 28.1 тэрбум төгрөг буюу 5.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 288.8 тэрбум төгрөг буюу 2.0 дахин өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.8 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2015 оны 4 дүгээр сарын эцэст 747.0 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 44.1 тэрбум төгрөг буюу 6.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 130.9 тэрбум төгрөг буюу 21.2 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.9 нэгжээр өссөн байна.

Банкнаас бусад санхүүгийн салбар:

Зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 329.3 тэрбум төгрөгөөр буюу 20.07 хувиар буурч, 1,311.0 тэрбум төгрөг болсон байна. 2015 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 61 удаагийн арилжаагаар 89 компанийн 12.9 сая ширхэг хувьцааг 3.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдээс харахад Засгийн газрын бондын арилжаанаас бусад үзүүлэлтүүд буурах хандлагатай байна.

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 170.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 45.2 тэрбум төгрөгөөр буюу 30 хувиар өссөн байна. Нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 13,4 хувиар өсөхөд дээр дурьдсан жолоочийн даатгалын нөхөн төлбөрийн хэмжээний өсөлт нөлөөлжээ. Даатгалын салбарын хөгжлийн үзүүлэлтүүдээс харахад өссөн дүнтэй байгаа боловч иргэд, аж ахуйн нэгжид хүртээмжтэй байдал нь сул байна.

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 395 банк бус санхүүгийн байгууллага нь 515,9 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт зээлийн багцын үлдэгдлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 35.3 хувиар нэмэгдсэн байх ба нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээл 1.1 дахин, чанаргүй зээлийн эзлэх хувь 1.0 дахин өссөн байна.

Хадгаламжийн зээлийн хоршооны нийт активын хэмжээ 85.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс даруй 9.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Цэвэр зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,251 тэрбум төгрөгөөр буюу 15.0 хувиар өссөн бол чанаргүй зээлийн үлдэгдэл 0,320 тэрбум төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн байна. Тайлант улиралд ХЗХ-дын нийт зээлийн багц 71,58 тэрбум төгрөг байгаа нь активын 83.0 хувийг, цэвэр зээл 70,07 тэрбум төгрөг буюу активын 82.0 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 56,6 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 66.1 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 55,3 тэрбум төгрөг буюу 97.7 хувь нь 10,375 гишүүний хугацаатай хадгаламж байгаа бол 1,308 тэрбум төгрөг буюу 2.3 хувь нь 3,824 гишүүний хугацаагүй хадгаламж байна.

Улсын төсөв: Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2015 оны эхний 4 сард 1,675.0 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1,919.8 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 244.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 139.2 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 7.8 нэгжээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Гадаад худалдаа, төлбөрийн баланс: Гадаад худалдааны тэнцэл 2014 оны эхний 4 сард 94.0 сая ам.долларын алдагдалтай байсан бол 2015 оны эхний 4 сард 418.0 сая ам.долларын ашигтай гарчээ. 2015 оны 1 дүгээр улиралд урсгал данс 43.0 сая ам.долларын, хөрөнгө ба санхүүгийн данс 127.0 сая долларын алдагдалтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 271.0 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын албан нөөц тэр хэмжээгээр буурчээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад өрийн хэмжээ: Тайлант хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 111.0 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 391.0 сая ам.доллараар буурчээ. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2015 оны 1 дүгээр улирлын байдлаар 20,895.0 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 953.0 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Салбараар нь авч үзвэл, Улсын салбар: Засгийн газар, Монголбанкны гадаад өр 702.0 сая ам.доллараар нэмэгдэж 5,432.0 сая ам.долларт хүрчээ.

Хувийн хэвшил: Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн жилийн хугацаанд 251.0 сая ам.доллараар нэмэгдэж 15,463.0 сая ам.долларт хүрээд байна.

Инфляцийн түвшин: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2015 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 0.9 хувь, оны эхнээс 2.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 9.2 хувиар өслөө. Ерөнхий индекс 2015 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 0.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Шигтгээ-1:

Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл, байдал болон олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнэ ханш цаашид өсөх хандлага ажиглагдахгүй байгаа зэрэг мэдээлэлд тулгуурлан товч дүгнэхэд, Монгол Улсын уул уурхайн түүхий эдийн олборлолт, үйлдвэрлэл, экспортын орлогод тодорхойгүй байдал үүсэх эрсдэл өндөр байна.

Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засагт ирээдүйд бий болохуйц эрсдлүүдийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- БНХАУ-ын хэрэглээнд суурилсан эдийн засгийн тогтолцоог халах, мөнгөний нийлүүлэлтийг багасгах төрөөс баримталж буй бодлогоос хамааран тус улсын эдийн засгийн өсөлт ойрын хугацаанд саарах хандлага ажиглагдаж байгаа нь эргээд Монголын эдийн засгийн өсөлтийг сааруулах хандлагатай байна.
- Төв банкнаас баримталж буй мөнгөний хатуу бодлого нь нийт эдийн засаг дах капиталын дотогшлох урсгалыг сааруулж, санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлэх хандлагатай байна.
- Монголын төрөөс нийт эдийн засгийн эрэлт, нийлүүлэлтийг өсгөх бодлогыг цаашид үргэлжлүүлэн баримталвал гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ эрс буурч буй өнөөгийн нөхцөлд төлбөрийн тэнцлийн урсгал балансын тэнцвэрийг алдагдуулах, валютын ханшийг хэт өсгөх нөхцлийг бий болгох боломжтой.

Олон улсын валютын сангаас Монгол Улсын эдийн засагт цаашид бий болохуйц эрсдлийг дараах байдлаар томъёолжээ. Үүнд:

- Түүхий эдийн үнээс хэт хамааралтай байгаа нь эдийн засгийн бүтцийг хэт эмзэг байдалд хүргэж байна.
- Сангийн хэт тэлэх бодлого нь инфляцийн түвшинг нэмэгдүүлж, уул уурхайн салбараас бусад салбарын өсөлтийг удаашруулах, өрсөлдөөнийг хязгаарлах хандлагатай байна.
- Үл хөдлөх хөрөнгийн салбарт олгож байгаа зээлийн өсөлт нь эргээд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг алдагдуулах системийн хэмжээний эрсдлийг бий болгох хандлагатай байна.
- Инфляцийн түвшингийн өсөлт нь эдийн засагт тодорхойгүй байдлыг бий болгон улмаар аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгийг үнэгүйдүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

II БҮЛЭГ: ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Үнэт цаасны зах зээл нь олон нийтээс санхүүжилт босгохоор хувьцаа, өрийн хэрэгслээ мэргэжлийн зуучлагчаар дамжуулан зах зээлд гаргадаг нийлүүлэлтийн тал, ногдол ашиг болон ханшийн зөрүүнээс ашиг олох зорилго бүхий хөрөнгө оруулагч буюу эрэлтийн тал, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангаж, үнэ ханшийг тогтоох үүрэг бүхий арилжаа, төлбөр, тооцоо, клирингийн болон мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа, дэд бүтцээс бүрддэг нийлмэл тогтолцоо.

Хөрөнгө оруулагчдын эрх ашгийн хамгаалалт, нэгдсэн бодлого, дүрэм журмын зохицуулалт, олон нийтийн болон хөрөнгө оруулагчийн боловсролыг дээшлүүлэх нь мөн тэргүүлэх чиглэлийн нэг болоод байгаа билээ.

Манай улсын үнэт цаасны зах зээл үүсэн бий болоод даруй 20 гаруй жилийн нүүрийг үзсэн боловч олон улсын болон бүс нутгийн интеграцид нэгдээгүй, дэд бүтцийн байгууллагуудын уялдаа сул, өмч хувьчлалын арга хэрэгсэл хэлбэрээр анхлан үүссэн тул компанийн засаглал сул, мэдээлэл, тайлагналын ил тод байдлын тогтолцоо бүрдээгүй байна.

2.1. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн болон үндсэн үзүүлэлтүүд:

Зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар: Зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 329.3 тэрбум төгрөгөөр буюу 20.07 хувиар буурч, 1,311.0 тэрбум төгрөг болсон байна. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компанийн үнэлгээ нийт зах зээлийн үнэлгээний 87.26 хувийг эзэлж байна. Хөрвөх чадварын түвшин 0.02 байгаа нь хувьцааны арилжаа зогсонги, эргэцгүй болсныг илтгэж байна.

Хүснэгт-1


Д/Д	Зах зээлийн үнэлгээ /тэрбум ₮/	ЗЗҮ/ДНБ /хувиар/	Хөрвөх чадвар	Арилжааны хэмжээ /тэрбум ₮/	Топ-20 индекс	Бүртгэлтэй компанийн тоо	Мэргэжлийн оролцогчдын тоо
2007	716.3	15.6 %	0.09	10.2	10618.8	383	36
2008	515.9	8.4%	0.12	62.3	5583.2	376	46
2009	620.7	10.2%	0.04	23.2	6189.9	358	48
2010	1373.9	16.3%	0.05	92.9	14759.8	336	52
2011	2104.7	20.0%	0.05	350.2	21687.5	330	92
2012	1799.9	12.9%	0.08	145.1	17714.5	328	97
2013	1670.5	10.5%	0.06	98.6	16301.8	323	93
2014	1442.6	6.6%	0.02	60.4	14854.2	304	75

Хувьцааны арилжаа: 2015 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 61 удаагийн арилжаагаар 89 компанийн 12.9 сая ширхэг хувьцааг 3.5 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Тайлант хугацаанд 89 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 компанийн үнэт цаасны ханш өсч, 48 компанийн үнэт цаасны ханш буурч, 9 компанийн үнэт цаасны ханш тогтмол байна. Идэвхитэй арилжигдсан 30 үнэт цаас нийт арилжигдсан хувьцааны тоо ширхэгийн 99.65 хувь, үнийн дүнгийн 96.05 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд 12 удаагийн багцын арилжаагаар нийт 12 компанийн 10.9 сая ширхэг хувьцааг 1.5 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 43.63%-ийг эзэлжээ. Тайлант хугацаанд 1 удаагийн тендер саналын арилжаа явагдаж, “Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 202 ширхэг хувьцааг 711.4 мянган төгрөгөөр арилжсан байна.

График-1

Хувьцааны арилжаа



Засгийн газрын үнэт цаасны арилжаа: Тайлант хугацаанд Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 12 удаа явагдаж, 12, 28, 52 долоо хоногийн хугацаатай нийт 1.1 сая ширхэг үнэт цаасыг 108.1 тэрбум төгрөгөөр арилжаалсан нь нийт Засгийн газрын үнэт цаасны арилжааны 97 хувийг, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2.1 мянган ширхэг үнэт цаасыг 204.6 сая төгрөгөөр арилжаалсан нь 3 хувийг тус тус эзэлж байна.

График-2

Арилжааны хувь



Топ-20 индекс болон MSE ALL индексийн үзүүлэлт: Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 14766.05, доод үзүүлэлт 13095.77, дундаж үзүүлэлт 14004.60 нэгж байв. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3208.25 нэгжээр буюу 19.68 хувиар буурч, 13095.60 нэгж болжээ.

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн MSE ALL индексийг албан ёсоор тооцож эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд MSE ALL индексийн дээд үзүүлэлт нь 1000.00, доод үзүүлэлт нь 957.37, дундаж үзүүлэлт 980.90 нэгж байв. 2015 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар 958.34 нэгжид хүрчээ.

Тайлант хугацаанд Засгийн газрын үнэт цаасны арилжаанаас бусад үзүүлэлтүүд буурсан байх бөгөөд энэхүү бууралтад хувьцааны арилжааны хэмжээ эрс буурсан нь эргээд зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, ТОП-20 индексийн өөрчлөлтөд шууд нөлөө үзүүлсэн гэж дүгнэхээр байна. Хувьцааны арилжааны хэмжээ эрс буурахад гадаад дотоод орчны дараах хүчин зүйлс нөлөөлжээ.

Шигтгээ-2:

Гадаад болон дотоодын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа уул уурхайн компаниудын хувьцааны үнэ ханшийн бууралт, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны төвлөрөл

Олон нийтийн санхүүгийн болон хөрөнгө оруулалтын боловсрол дутмаг, үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг соёл суралцаагүй, банкны хадгаламжийн хүү өндөр

Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ хангалтгүй

Зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын хөгжил сул, хувьцаат компаниудын засаглал, мэдээлэл болон санхүүгийн тайлагналын ил тод байдал хангалтгүй

Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглаж хувьцааны үнэ ханшид нөлөөлөх хандлага өндөр.

2.2. Үнэт цаас гаргагчид болон хөрөнгө оруулагчдын бүтэц:

Үнэт цаас гаргагч компанийн санхүүгийн болон засаглалын үзүүлэлтүүдийг харуулбал:

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар 137 компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлан хуралдуулсан бол 133 компани санхүүгийн тайлангаа Хороонд ирүүлж, 4 компани 1.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн байна.

Хүснэгт-2

Үнэт цаас гаргагч компанийн хэлбэр	Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй	Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй
Төрийн өмчийн	30	21
Төрийн өмчийн оролцоотой	11	15
Хувийн өмчийн	262	201
Нийт	303	237

Шигтгээ-3:

Төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд ишлжих шатанд төрөөс иргэдэд үнэ төлбөргүйгээр хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг тарааж, уг эрхийн бичгээр хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн хувьцааг эзэмшүүлснээр үнэт цаасны зах зээл дэх хөрөнгө оруулагчийн тогтолцоо бий болсон. Гэвч үнэт цаасны зах зээлийн талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг, мэргэжлийн зуучлагч байгууллагын ёс зүйгүй үйлдэл, хувьцаат компанийн бүртгэлийн шаардлага хангалтгүй, үнэлгээ хэт доогуур байснаас шалтгаалан цөөн тооны этгээдүүдийн гарт дийлэнх хувьцаат компаниудын хяналтын багц төвлөрч, компанийн засаглал, ил тод байдал, тайлагналын зарчим алдагдсан

Хорооны зүгээс Компанийн засаглалын үндэсний зөвлөл болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-тай хамтран бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах чиглэлээр ТОП-20 хувьцаат компаниудтай компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх, сайн засаглалтай компани болоход хичээн ажиллах тунхаг

бичигт гарын үсэг зурж, хувьцаат эзэмшигчдийн хурал ба эрх сэдвээр онол практикийн хурал, семинар, үнэт цаасны компаниудад хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалтыг зохион байгуулав

УИХ-ын 2015 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн хүрээнд төрийн өмчийн нэр бүхий 9 хувьцаат компанийг нэмэлт хувьцаа гаргах замаар хувьчлах ажлыг Төрийн өмчийн хороотой хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна

75 хувиас дээш төвлөрөлтэй хувьцаат компаниудыг нэмж үнэт цаас гаргах, хувьцаагаа хуваах замаар төвлөрлийг бууруулах, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, үнэт цаасны арилжаа нь зогссон, бүртгэлийн шаардлага хангаагүй компаниудыг биржийн бүртгэлээс хасах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Хөрөнгө оруулагчдын бүтэц: Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид шинээр 4,698 данс нээгдсэнээс Монгол Улсын 4,679 иргэн, гадаадын 12 иргэн, Монгол Улсын 7 аж ахуй нэгж шинээр данс нээлгэсэн байна. Төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 790,561 данс нээгдсэнээс Монгол иргэдийн 786,177, гадаад иргэдийн 1,771, Монголын аж ахуйн нэгжийн 2,440, гадаадын аж ахуйн нэгжийн 173 данс тус тус бүртгэлтэй байна.

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар “ҮЦТТТХТ” ХХК-д бүртгэлтэй 790.0 мянга гаруй данснаас зөвхөн 10.0 мянган харилцагчийн данс арилжаанд идэвхтэй оролцдог гэсэн судалгаа хийгдсэн ба “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хийгдсэн 111.7 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас болон хувьцааны арилжаанд оролцсон хөрөнгө оруулагчдын бүтцийг үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт-3

д/д	Хөрөнгө оруулагчдын бүтэц	Арилжааны үнийн дүн	Арилжаанд эзлэх хувь
1.	Гадаадын аж ахуйн нэгж	699.1 сая төгрөг	0.63%
2.	Гадаадын иргэн	810.0 сая төгрөг	0.72%
3.	Дотоодын аж ахуйн нэгж	99.2 тэрбум төгрөг	88.8%
4.	Дотоодын иргэн	11.0 тэрбум төгрөг	9.9%

Гадаадын аж ахуйн нэгж, иргэдийн үнэт цаасны арилжаанд оролцох хувь 2013 оноос хойш хугацаанд тасралтгүй буурах хандлагатай байгаа бөгөөд үүнд дараах гадаад, дотоод хүчин зүйлс нөлөө үзүүлж байна.

Шигтгээ-4:

Олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнэ ханиш унасантай холбоотойгоор хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудын хувьцааны үнэ дагаж буурсан

Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын өмчлөх эрхийг баталгаажуулах кастодианы үйлчилгээ зах зээлд бүрэн нэвтрээгүй, хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо, нэр төрөл дутмаг

Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих татварын эрх зүйн орчин бүрдээгүй

Зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын уялдаа холбоо сул.

2.3. Мэргэжлийн зуучлагч байгууллага:

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн оролцогчдыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт-4

д/д	Тусгай зөвшөөрлийн Төрлөөр	Зуучлагч байгууллагын тоо
1.	Арилжаа эрхлэх	1
2.	Төлбөр тооцоо, хадгаламжийн	1
3.	Харилцагчийн нэрийн өмнөөс зуучлалын үйлчилгээ үзүүлэх	10
4.	Хөрөнгө оруулалтын менежментийн	3
5.	Брокер, дилерийн	66
6.	Кастодианы үйлчилгээ үзүүлэх	2
7.	Давхардсан тоогоор андеррайтерийн	25
8.	Давхардсан тоогоор хөрөнгө оруулалтын зөвлөхийн	15

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-д нийт 62 үнэт цаасны компани бүртгэлтэй байгаагаас 42 компани үнэт цаасны арилжаанд оролцжээ. Үүнээс Засгийн газрын үнэт цаасны арилжаанд “Тэнгэр капитал ҮЦК” ХХК, “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК, “Ард капитал групп ҮЦК” ХХК, “Голомт секьюритис ҮЦК” ХХК, “Би Ди Сек ҮЦК” ХК, “Дэү секьюритис Монгол ҮЦК” ХХК-иуд хамгийн их дүнтэй гүйлгээг хийжээ. Хувьцааны арилжаанд “Би Ди Сек ҮЦК” ХК, “Монгол секьюритис ҮЦК” ХХК, “Стандарт инвестмент ҮЦК” ХХК-иуд тус тус хамгийн их үнийн дүн бүхий гүйлгээг хийсэн байна.

Шигтгээ-5: Өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэвэл, үнэт цаасны зах зээлийн зуучлагч байгууллагуудыг тооноос чанарт шилжүүлэх, цөөн тооны санхүүгийн болон нөөцийн чадавхтай компаниудаар хөрөнгө оруулагчдад зуучлалын үйлчилгээг иж бүрэн хүргэх, бүртгэлтэй компаниудын засаглал, мэдээлэл, тайлагналын ил тод байдлыг сайжруулах, бүртгэлийн нэр хүндийг өсгөх нь зах зээлийн хөгжлийн богино хугацааны зорилт болоод байна

Үнэт цаасны зах зээлийнталаар хөгжингүй орнуудын туршилагаас харахад банк, түүний охин, хараат компаниудад брокер, андеррайтер, кастодиан, хөрөнгө оруулалтын сан, менежментийн үйл ажиллагаа эрхлэхэд таатай эрх зүйн орчин бүрдүүлснээр зах зээлийн зуучлалын үйлчилгээг гүнзгийрүүлж, улмаар зээл, хадгаламжийн хүүгийн түвшинг бууруулжээ. Манай орны хувьд Банкны тухай хуулийн 6.2 дахь хэсэгт банк, түүний охин, хараат компани Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэйгээр нэр бүхий 7 үйлчилгээг үнэт цаасны болон даатгалын зах зээлд эрхлэхээр зохицуулагдсан байдаг

Иймд үнэт цаас, даатгалын салбар дахь банкны оролцоог нэмэгдүүлснээр санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, улмаар зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг өсгөх боломжтой.

2.4. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц, зохицуулалт:

2015 оны эхний улирлын байдлаар төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн дансаар нийт 186 харилцагчийн дансанд 671 удаагийн 532.3 тэрбум төгрөгийн орлогын, нийт 1008 харилцагчийн 1255 удаагийн 533.7 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус гүйцэтгэжээ. “ҮЦТТТХТ” ХХК-иар дамжуулан “Голомт” банк 463.0 сая төгрөг, “Хаан” банк 22.6 сая төгрөг, “Хас” банк 425.6 сая төгрөг, “Худалдаа хөгжлийн” банк 362.2 сая төгрөгийн үнэт цаасны төлбөрийг банк хоорондын гүйлгээгээр гүйцэтгэсэн байна.

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үр ашигтай, найдвартай, хурдан шуурхай байдал нь хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэл, хөгжилд голлогч нөлөөллийг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн бирж дээр хийгдсэн хэлцлийн дүнд үнэт цаасны өмчлөх эрх, мөнгөн хөрөнгө хурдан шуурхай шилжүүлэх асуудал зах зээлийн дэд бүтцийн уялдаа, технологийн хөгжлөөс ихээхэн хамаардаг.

1995 оноос үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хийгдэж эхэлсэн бөгөөд 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд “ЕСМ” ХХК-ийн боловсруулсан арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн програм хангамжийг ашиглаж байсан.

2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТТХТ” ХХК-д арилжаа, тооцоо, хадгаламжийн МІТ системийг албан ёсоор ашиглаж эхэлсэн. МІТ систем нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдын ажиллагааг дэмжсэн, их хэмжээний хэлцлийг нэг зэрэг, цаг хугацааны хоцролтгүй биелүүлэх, маржин ба зээлээр үнэт цаас худалдах, худалдан авах, кастодианы дэд програмыг агуулснаараа давуу талтай.

Зураг-1

Өнөөгийн үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц:




Гэвч үнэт цаасны төлбөр тооцооны бие даасан дундын зуучлалын үйлчилгээ манайд бий болоогүй, нэгдсэн програм хангамжийг хөгжүүлж чадахгүй байгаагаас санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон зээлээр үнэт цаас худалдах, худалдан авах маржин арилжааг бий болгоход шаардлагатай үнэт цаасны төлбөр тооцооны баталгаажуулалтад бэрхшээл үүсч байна.

Засгийн газрын 2015 оны 147 дугаар тогтоолоор “ҮЦТТТХТ” ХХК-ийг төлбөр тооцооны, төвлөрсөн хадгаламжийн чиглэлээр 2 тусдаа бие даасан байгууллага бий болгохоор шийдвэрлэсэн бөгөөд цаашид үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн уялдаа холбоог сайжруулахад төлбөр тооцооны чиглэлээр байгуулагдах шинэ байгууллагыг Цахим гүйлгээний үндэсний төвд түшиглэн дундын зуучлалын төвийг байгуулах, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагын хэлбэрт шилжүүлэх, хувьчлах нь зүйтэй байна.

Бие даасан дундын зуучлалын төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэн үнэт цаас, хөдөө аж ахуйн, уул уурхайн биржүүдийн төлбөр тооцоог гүйцэтгэх чиглэлд өргөтгөх, кастодианы үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх зэрэг дэд бүтцийн ажлын уялдааг хангах талаар ажиллах шаардлага бий болоод байна.

Цаашдын дэд бүтцийн хандлагыг схемээр үзүүлбэл:

Зураг-2. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хандлага



III БҮЛЭГ: ДААТГАЛЫН САЛБАРЫН ТОЙМ

3.1. Даатгалын салбарын өнөөгийн байдал:

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хувийн арилжааны даатгалын тогтолцоо үүсэх нөхцөл бүрдсэн бөгөөд УИХ-аас 2004 онд Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2011 онд албан журмын даатгалын төрөл болох Жолоочийн даатгалын тухай хуулийг баталсан.

Олон улсын санхүүгийн зах зээлийн явцаас харахад даатгалын салбар нь өөрийн бүрдүүлсэн нөөц сангуудаар дамжуулан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг бөгөөд ингэснээрээ үнэт цаасны зах зээлийн эрэлтийн талыг идэвхжүүлэгч үндсэн хэрэгсэл болж өгдөг.

Манай орны хувьд үнэт цаасны зах зээл нь хөгжиж буй зах зээлийн шинжийг агуулсан, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, нэр төрөл, хүртээмж дутмаг, хөрвөх чадварын түвшин доогуур байгаа нь эргээд даатгалын салбарын оролцоог хязгаарлах үндсэн шалтгаан болоод байна.

Даатгалын тухай хуулиар даатгалын талаар баримтлах бодлогыг Сангийн яам боловсруулахаар заасан ба улсын төсвийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий яам арилжааны даатгалын салбарын бодлогыг боловсруулах нь оновчтой биш хувилбар болохыг өнөөгийн нөхцөл байдал харуулж байна. Гэтэл олон улсын туршлага, ялангуяа, даатгалын хөгжингүй зах зээлтэй азийн орнууд болох Япон, Солонгосын санхүүгийн үйлчилгээний зохицуулагч байгууллагууд нь арилжааны даатгалын салбарын төрийн бодлогыг боловсруулж, хяналтыг хэрэгжүүлж байна.

Ингэснээр арилжааны даатгалын урт хугацааны болон ердийн даатгалын төрлийг зөв оновчтой уялдуулах, шинэ төрлийн албан журмын даатгалын эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар иргэд, аж ахуйн нэгжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, төрийн нийгмийн даатгалын сангуудад учирч буй ачааллыг бууруулах боломжийг бүрдүүлдэг байна.

Манай улсын даатгалын салбарын хөгжлийн хандлагаас харахад ердийн даатгалын төрөл болох сайн дурын даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл жил ирэх тусам эрчимтэй нэмэгдэж байгаа хэдий ч салбарын талаарх олон нийтийн боловсрол дутмаг байгаа тул хамрагдалт хангалтгүй хэвээр байна. Учир нь арилжааны даатгалын компаниудаас санал болгож буй бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд үүсч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санхүүгийн, зээлийн, агаарын хөлгийн, иргэдийн амьдралын баталгааг хангах зорилгоорамь нас, эрүүл мэнд, хөрөнгийн даатгал, малын индексжүүлсэн болон газар тариалангийн даатгал зэрэг бүтээгдэхүүний нэр төрлүүд сайн дурын үндсэн дээр үүсч даатгалын харилцааг үүсгэдэг.

Улсын Их Хурлаас 2011 онд албан журмын даатгалын төрөл болох Жолоочийн даатгалын тухай хуулийг баталсан нь авто тээврийн хэрэгсэл эзэмшигч аж ахуй нэгж, иргэн бүр заавал даатгуулах хуулийн шаардлага бий болсноор 2015 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар энэ онд 299,468 жолоочийн даатгалын гэрээ байгуулагдсан байна.

Дээрхээс дүгнэвэл арилжааны даатгалын салбарыг чадавхжуулах чиглэлээр албан журмын даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна.

3.2. Салбарын статистик үзүүлэлтүүд:

2015 оны 1 дүгээр улирлын даатгалын салбарын нийт активын 85 хувийг ердийн, 3 хувийг урт хугацаат, 12 хувийг хөдөө аж ахуйн давхар даатгал тус тус бүрдүүлжээ. Харин гадаад орнуудын даатгалын салбарын үзүүлэлтүүдээс харахад, нийт даатгалын салбарын активын дийлэнх хувийг урт хугацааны даатгалын компаниудын актив бүрдүүлдэг байна.

Даатгалын салбарт ердийн даатгалын 16, урт хугацааны даатгалын 1, хөдөө аж ахуйн давхар даатгалын 1 компани, даатгалын компаниудын 259 салбар, 3210 даатгалын төлөөлөгч, 15 актуарч, даатгалын зуучлагч 33 компани, даатгалын хохирол үнэлэгч 21 компани нийт 3556 тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөн улирлын өссөн дүнгээр нийт 316,782 иргэн, аж ахуйн нэгж даатгуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 45 хувиар буурчээ. Үүнд ердийн даатгалын даатгуулагчийн тоо буурч, харин урт хугацаат даатгуулагчид өссөн байна.

Гадны орнуудын туршлагаас харахад нийгмийн хамгааллын салбарт баримтлах бодлого, стратегийн үндсэн зорилт нь нийгмийн даатгалын салбарт учирч буй дарамтыг бууруулах зорилгоор урт хугацаат хувийн даатгалыг хөгжүүлэхийг чухалчилсан байх ба “pay as you go” зарчим хэрэгжиж буй орнуудад нийгмийн даатгалын салбарын орлого, хуваарилалтын харьцаа алдагдсанаар нийгмийн шинжтэй хямралт байдлыг бий болгодог байна.

Манай улсын хувьд амьдралын даатгалын үйлчилгээг хөгжүүлэх богино, урт хугацааны хөтөлбөрийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамтай хамтран боловсруулж, хувийн тэтгэврийн болон хуримтлалын даатгалын ач холбогдлыг иргэдэд таниулах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Хүснэгт-5

Даатгалын салбарын үйл ажиллагааны үзүүлэлтүүд /тэрбум.төгрөг/

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2014	2015.I
Нийт хөрөнгийн хэмжээ	56.7	81.3	107.6	126.4	152.5	170.2
Давхар даатгалын хураамж	7.5	10.7	20.8	26	31.6	20.8
Даатгалын нөөц сан	29.1	36.1	48.2	57.3	66.1	69.81
Даатгалын хохирлын харьцаа	34%	33%	34.9%	42%	43%	39.8%
Хураамжийн орлого	31.8	47.5	79	93.9	108.7	35.71
Нөхөн төлбөр	6.8	10	16.9	26.5	31.5	9.2

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 170.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 45.2 тэрбум төгрөгөөр буюу 30 хувиар өссөн байна. Нөхөн төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 13,4 хувиар өсөхөд дээр дурдсан жолоочийн даатгалын нөхөн төлбөрийн хэмжээний өсөлт нөлөөлсөн байна.

Хүснэгт-6

Даатгуулагчийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ

	Даатгуулагчийн тоо		Нөхөн төлбөр авсан	
	Хувь хүн	ААН	Хувь хүн	ААН
2010	676,676	14,989	9,788	9,13
2012	1,116,997	13,215	10,783	10,649

2013	818,451	60,097	14,636	12,95
2014	1,004,260	82,577	13,707	42,093
2014.I	550,709	17,393	9,637	4297
2015.I	313,418	33,64	11,125	4,677

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар хураамжийн орлого 35.7 тэрбум төгрөг байгаа ба түүний 85 хувийг 4 төрлийн бүтээгдэхүүний орлого бүрдүүлжээ. Орлогын бүтцийг задалвал: Нийт орлогын 26 хувийг хөрөнгийн, 24 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын, 18 хувийг авто тээврийн хэрэгслийн, 17 хувийг гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын орлого тус тус эзэлж байна.

Хөрөнгийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлогын хэмжээ бусад бүтээгдэхүүний орлогоос өндөр байгаад дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- *Төрөөс хэрэгжүүлж буй иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд орон сууцны хөнгөлөлттэй зээлийг олгоход заавал хөрөнгийн даатгалд даатгуулахаар зохицуулагдсан*
- *Жолоочийн даатгалын тухай хуулиар жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор албан журмын даатгалын төрлийг зохицуулж өгсөн зэрэг нь бүтээгдэхүүний хураамжийн орлогын хэмжээг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлжээ*
- *Даатгалын хураамжийн орлогын төвлөрөл, бүтээгдэхүүний нэртөрлөөс үзэхэд, иргэд, аж ахуйн нэгж дээр дурдсан албан журмын даатгал бус сайн дурын даатгалд төдийлөн даатгуулах сонирхолгүй байгаа нь даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний ач холбогдлын талаарх олон нийтийн боловсрол, мэдээлэл хомс байгаатай холбоотой.*

Япон улсын ЖАЙКА төслийн зөвлөх багаас 2014 оны 3 дугаар сард гаргасан “Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн хөгжил болон хяналт, зохицуулалтын чадавхийг бэхжүүлэх судалгаа”-ны тайланд даатгалын компаниуд олон нийтийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг боловч компанийн санхүүгийн байдлаас хамаарч энэхүү үйл ажиллагаа хязгаарлагддаг гэж дурдсан байна.

Цаашид Хорооны зүгээс даатгалын салбарт иргэд, аж ахуйн нэгжийн хамрагдалтыг өсгөх чиглэлээр албан журмын даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх төрөлжсөн хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-д өргөн барих ажлыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-т бизнес эрхлэгчдэд учирдаг эрсдлийг багасгах, санхүүжилтийн өртгийг бууруулах зорилгоор хувийн хэвшилтэй хамтран экспортын даатгалын компани байгуулах, Барилга угсралтын ажлын, эмчийн хариуцлагын, хуульчийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хуулийн төслүүдийг боловсруулахаар тусгасан. Тогтоолоор албан журмын даатгалын шинэ хуулийн төслүүдийг 2015 оны эхний хагас жилд багтаан боловсруулж, хэрэгжүүлэхийг Сангийн яаманд үүрэг болгосон.

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар давхар даатгалын хураамжийн орлогын дүнг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт-7

Хураамжийн орлогын үзүүлэлтүүд %	2010	2011	2012	2013	2014	2015.I
----------------------------------	------	------	------	------	------	--------

Ердийн даатгал	Нийт хураамжийн орлого	100	100	100	100	100	100
	(Давхар даатгалын хураамж)	23.68	22.60	26.47	27.95	29.41	59.16
	(Буцаасан даатгалын хураамж)	0.67	0.39	0.76	0.84	3.01	0.00
	Цэвэр хураамжийн орлого	75.65	77.01	72.77	71.20	67.59	40.84

Манай улсад үндэсний давхар даатгалын компани үйл ажиллагаа явуулдаггүйгээс шалтгаалан даатгалын компаниудын хураамжийн нийт орлогын 31.62 хувь нь гадаадын давхар даатгалын компаниудад шилжиж, валютын гадагшлах урсгалыг нэмэгдүүлснээр ханшийн огцом хэлбэлзэл үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх эрсдэл өндөр байна.

Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийн 11.3 дахь хэсэгт Үндэсний давхар даатгалын корпораци байгуулахаар заасан ба ингэснээр даатгалын компаниудын давхар даатгалын хураамжид төлж буй валютын гадагшлах урсгалыг бууруулах, уул уурхай, аж үйлдвэр, тээврийн салбарын хөрөнгийг даатгах боломж бүрдэнэ.

Цаашид гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниудын тоног төхөөрөмжийн даатгалыг үндэсний даатгалын компаниар даатгуулах чиглэлээр Хөрөнгө оруулалтын тухай хуульд нарийвчилсан зохицуулалтыг оруулснаар дотоодын зах зээлд чиглэсэн валютын урсгалыг нэмэгдүүлэх, макро түвшинд төлбөрийн балансыг тэнцвэржүүлэх боломжтой.

3.3. Даатгалын салбарын бүтээгдэхүүн үйлчилгээ:

2015 оны 1 дүгээр улиралд санхүүгийн зах зээлд ердийн 16, урт хугацаат 6, хөдөө аж ахуйн давхар даатгалын 1, нийтдээ 23 төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг 3,556 даатгалын мэргэжлийн оролцогчид Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхтэйгээр олон нийтэд санал болгон борлуулж байна.

Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгалын компаниудын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдээгүй хэдий ч жолоочийн албан журмын даатгалын бүтээгдэхүүн шинээр бий болсонтой холбоотойгоор салбарын болон зуучлагчдын тоо эрс өссөн нь даатгалын бүтээгдэхүүний борлуулалтын сувгийг ихэсгэжээ.

Улсын Их Хурлаас 2010 онд Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан ба уг хуулийн 6.2 дахь хэсэгт үнэт цаасны зах зээл болон даатгалын салбарын нэр бүхий 7 төрлийн үйлчилгээг банк, түүний охин, хараат компанид Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхлэхээр заасан.

Тайлант хугацаанд нийт 7 арилжааны банк даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрлийг Хорооноос авч, үйл ажиллагаа явуулж байна. Япон болон Солонгос улсуудын туршлагаас үзэхэд банк, түүний охин, хараат компаниудын үнэт цаасны зах зээл болон даатгалын салбар дахь зуучлалын үйл ажиллагааг өргөжүүлснээр урт хугацаандаа зээл, хадгаламжийн хүүгийн түвшинг бууруулж чаджээ. Хорооноос тусгай зөвшөөрөл авсан арилжааны даатгалын компаниуд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж байгаагүй болно.

Даатгалын салбар нь иргэд болон аж ахуйн нэгжүүдэд ирээдүйд учрах эрсдлийг бууруулах, нөөц сангийн хөрөнгөөр үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалт хийж санхүүжилтийн урт хугацааны эх үүсвэр болгон ашигласнаар тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангаж, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Гадаад орнуудын туршлагаас харахад, урт хугацааны даатгалын нөөц сангийн хөрөнгө нь капиталын үр дүнтэй хуваарилалтыг бий болгох замаар урт хугацаат санхүүжилтийн тогтолцоог дэмждэг бол ердийн даатгал нь хөрөнгө оруулалтын богино хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлдэг.

3.4. Даатгалын салбарын хөгжлийн үзүүлэлтүүд:

Даатгалын хөгжлийг эдийн засаг дахь даатгалын зуучлалын эзлэх хувь(гүнзгийрэлт), нэг хүнд ногдох даатгалын хувь хэмжээ(нягтрал) гэсэн ерөнхий 2 үндсэн үзүүлэлтээр үнэлдэг.

Даатгалын гүнзгийрэлт

Эдийн засагт даатгалын салбарын үзүүлж буй нөлөөг даатгалын гүнзгийрэлтээр илэрхийлдэг бөгөөд тус үзүүлэлтийг даатгалын салбарын нийт хураамжийн орлогыг нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулан тооцдог.

Хүснэгт 8

Д/Д	Цэвэр хураамжийн орлого /сая.төг/	Даатгалын гүнзгийрэлт	Урт хугацааны даатгалын цэвэр хураамжийн орлого /сая.төг/	Урт хугацааны даатгалын гүнзгийрэлт	Ердийн даатгалын цэвэр хураамжийн орлого /сая.төг/	Ердийн даатгалын гүнзгийрэлт
2010	23 820.00	0.24414%	20.00	0.00020%	23800.00	0.24394%
2011	36 564.09	0.27755%	415.53	0.00315%	36 148.56	0.27440%
2012	57 485.93	0.34447%	750.85	0.00450%	56 735.08	0.33997%
2013	67 103.87	0.35100%	961.06	0.00503%	66 142.81	0.34597%
2014	73 943.51	0.33850%	1 419.40	0.00650%	72 524.11	0.33201%
2015.I	14 373.38	0.31657%	509.08	0.01121%	13864.30	0.30536%

Жич: Даатгалын гүнзгийрэлтийг тооцохдоо давхар даатгалын хураамж эдийн засгийн эргэлтэд ордоггүйн улмаас цэвэр хураамжийн орлогыг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан болно.

График-3



2015 оны 1 дүгээр улирлын байдлаар нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх цэвэр хураамжийн нийт орлого 0.32 хувь, ердийн даатгалын цэвэр хураамжийн орлого 0.31 хувийг тус тус эзэлж байна. Хөгжиж буй орнуудын даатгалын гүнзгийрэлт дунджаар 6.3 хувь байдаг ба манай улсын хувьд олон улсын дунджаас 20 дахин бага байгаа нь даатгалын салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл сул байгааг илтгэж байна.

Даатгалын нягтрал:

Энэхүү үзүүлэлт нь тухайн хугацааны нийт хураамжийн орлогыг хүн амын тоонд харьцуулан тооцох ба хүн ам даатгалд хэрхэн хамрагдсаныг илэрхийлдэг. Хүснэгт 9-өөс үзэхэд даатгалын нягтралын үзүүлэлт сүүлийн таван жилийн байдлаар өссөн дүнтэй харагдаж байгаа боловч өсөлтийн хувь нь буурах хандлагатай байна.

Хүснэгт-9

Д/Д	Нягтрал (Хураамжийн орлого/хүн ам)	Өсөлт %	Хураамжийн орлого (төгрөг)	Хүн амын тоо	Хураамжийн орлогын өсөлт %	Хүн амын тооны өсөлт %
2010	8 627.41		23 820 000 000.00	2 760 968	-	-
2011	13 004.42	51	36 564 094 895.42	2 811 666	54	2
2012	20 045.70	54	57 485 930 433.12	2 867 744	57	2
2013	22 900.18	14	67 103 867 873.22	2 930 277	17	2
2014	24 681.16	8	73 943 509 753.95	2 995 949	10	2

График-4



Зохистой харьцааны үзүүлэлтүүд

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгалын компаниудын зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт-10

Зохистой харьцаанууд	Боломжит түвшин	Нийт дүнгээр	Хамгийн өндөр үзүүлэлт	Хамгийн бага үзүүлэлт	ТАЙЛБАР
Нийт хөрөнгийн өгөөж (%) = (Даатгалын цэвэр хураамж / Нийт хөрөнгө)	-	8.15	19.81	0.61	
Зардлын харьцаа (%) = (ҮАЗ / ОТхураамж)	25 ≤ 60	72.84	115.22	46.47	Компаниудын хувьд 46.47-115.22 хувь байгаа нь үйл ажиллагааны зардал өндөртэйг харуулж байна.
Өөрт үлдэх эрсдлийн харьцаа (%) = (Цэвэр хураамж / Нийт хураамж)	40 ≤ 80	39.97	100	13.03	

СЗХ | Зохицуулалтын салбарын нэгдсэн тойм

Хосолсон харьцаа (%)= (Нөхөн төлбөр + ҮАзардал/ОТхураамж)	85 ≤ 105	114.23	155.52	76.58	Энэ харьцаа нь 100 хувиас их нөхцөлд компанийн хөрөнгө оруулалтын ашигтай ажиллахыг шаарддаг.
Хохирлын харьцаа (%)= (Төлсөн нэхэмжлэл/ ОТхураамж)	-	52.1	77.94	4.99	

IV БҮЛЭГ: БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

4.1. Бичил санхүүгийн салбарын өнөөгийн байдал:

1970 оноос хойш бичил санхүүгийн зах зээл нь хүрээгээ хурдтай тэлсэн бөгөөд бага орлоготой иргэдийг ядуурлаас гаргах, эдийн засгийн өсөлтийг дэмжих үндсэн зорилгод чиглэгдэж байсан. Дэлхийн эдийн засгийн хямрал нь банкны салбарт хүчтэй нөлөө үзүүлж байхад бичил санхүүгийн салбар нь хямралд бага өртдөг онцлогтой.

Олон улсад “бичил санхүү” гэдэг нь бага орлоготой, ядуу иргэдэд барьцаагүй зээл, мөнгөн хадгаламж, даатгал, мөнгөн гуйвуулга, лизинг, мөнгөн шилжүүлэг зэрэг цогц санхүүгийн үйлчилгээг үзүүлэхийг ойлгож байгаа бөгөөд бичил санхүүгийн үйлчилгээг банк болон бичил санхүүгийн байгууллагууд гүйцэтгэдэг.

Бичил санхүүгийн салбар нь уламжлалт банкуудын гүйцэтгэж чадахгүй олон зуун сая иргэдийн хадгаламжийг хуримтлуулж чаддагаараа онцлогтой. Хөгжиж буй эдийн засагтай улсад бага орлоготой, ядуу иргэд нь эрсдэлтэй бүлгийн тоонд ордог учир банкны үйлчилгээг авч чаддаггүй. Иймд тэдгээр иргэдэд уламжлалт банкнаас өөр хямд төсөр санхүүгийн үйлчилгээг авах сонирхол их байдаг.

Бичил санхүү нь уламжлалт банкны системд хэрхэн нөлөө үзүүлж байна гэдэг нь их чухал асуудлын нэг бөгөөд 1950-1970 оны хооронд хөгжиж буй эдийн засагтай орнуудад банкууд төрийн өмчит, гадаадын хөрөнгө оруулалтын хэлбэртэйгээр үүсэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 1980-аад оноос эхлэн хувийн банкууд гарч ирсэн. Банкны нөөц хөрөнгө, дүрмийн сан, зээлийн хүү зэрэгт тавигдах хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага өндөр зэргээс шалтгаалан эрсдэлтэй, зардал их гарах, бага орлоготой иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэггүй байсан. Гэвч өнөө үед банкны салбар хүрээгээ улам тэлж байгаа бөгөөд банкны өрсөлдөөн нэмэгдэж байгаа учир шинэ зах зээл рүү хөрөнгө оруулалт хийх сонирхол улам ихэссэн. Энэ хүрээнд банкууд бичил санхүүгийн зах зээлд оролцон эргэлтийн хөрөнгө шаардлагатай байгаа иргэдийн эрэлтийг хангаж ажиллах болсон.

Улс орны санхүүгийн хөрөнгө нь ихээхэн төвлөрсөн байдаг бөгөөд бага орлоготой, ядуу иргэдэд дээрх санхүүгийн хөрөнгөөс хүртэж, орлогоо нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал тул бодлогын түвшинд өрхийн санхүүг сайжруулахад гол анхаарлаа хандуулж, ядуу иргэдэд хүрэх санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж нээлттэй болгох шаардлагатай.

Олон улсад санхүүгийн хүртээмж, санхүүгийн хөгжлийг ДНБ-д харьцуулсан хувийн зээлийн түвшингээр тодорхойлдог бөгөөд хувийн зээлийн хэмжээ өсөх тусам ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээ нэмэгдэж, улмаар өрхүүд шаардлагатай санхүүжилтээ авч чадсанаар орлогын түвшин өсч, орлогын тэгш бус байдал болон ядуурлын хэмжээ буурсанаар эдийн засгийн үр өгөөж нэмэгддэг байна.

Томоохон олон улсын банкууд болох Citigroup, Deutsche bank, HSBC зэрэг банкууд нь тусдаа бичил санхүүгийн хэлтсийг байгуулан ажиллаж байна. Манай улсын хувьд Хаан банк, ХХБ зэрэг нь иргэдэд чиглэсэн санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, банкны баталгаатай санхүүгийн үйлчилгээг иргэдэд үзүүлснээр нэн тэргүүний зорилтот бүлэг болох бага орлоготой, ядуу иргэдэд даатгал, зээлийн үйлчилгээг бага зардлаар үзүүлэх боломжтой юм. Мөн банк бус санхүүгийн байгууллага буюу бичил санхүүгийн институц нь их хэмжээтэй зээлийн хэрэгцээг хангах нөөц хөрөнгөгүй учир банкууд бичил санхүүгийн зээлийн эрэлтийг хангах шаардлага тулгардаг байна.

Олон улсад томоохон хэмжээний актив, өөрийн хөрөнгөтэй, олон салбартай, иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг банкууд бичил санхүүгийн салбарт амжилттай оролцдог бөгөөд эдгээр банкууд нь бичил санхүүгийн салбарт хүчтэй өрсөлдөгч болж, бичил санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад шахалт үзүүлдэг.

Бичил санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхлэхэд эхний үед арилжааны банкуудад ихээхэн хэмжээний зардал чирэгдэл гардаг бөгөөд салбартаа байр сууриа олох, харилцагчдыг татахад цаг хугацаа их шаардагддаг.

Хэдий тийм боловч бичил санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд банкны салбартай хамтарч ажиллах, цаашид банкны салбарын цогц үйлчилгээг үзүүлэх, эсхүл банкуудад тодорхой эрх үүргээ шилжүүлж, арилжааны банкууд бичил санхүүгийн салбарт голлох үүрэгтэй оролцох шаардлага тулгарч байна.

Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр олон улсын бичил санхүүгийн түвшинд ойртож, сонгодог утгаар бага орлоготой, ядуу иргэдэд чиглэсэн барьцаа хөрөнгөгүй зээл, даатгал, хадгаламж, мөнгөн шилжүүлэг хийх зэрэг санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэх боломжтой болох бөгөөд ингэснээр ядуурлын түвшин тодорхой хэмжээгээр буурч, шаардлагатай санхүүжилтээ үйл ажиллагаандаа ашигласнаар иргэдийн орлогын түвшин өсөх хийгээд нийгэм эдийн засгийн үр өгөөж нэмэгдэх давуу талтай болно.

Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын хэмжээ 2006 оноос эхлэн өсөн нэмэгдсээр 2014 оны байдлаар 506.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны үеэс 125.7 тэрбум төгрөгөөр буюу 75.2 хувиар өссөн. Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын хэмжээ өсөхөд иргэд, хуулийн этгээдэд олгосон зээлийн хэмжээний өсөлт гол нөлөөг үзүүлсэн. 2015 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын нийт олгосон зээл ДНБ-ийн 7.34 хувийг бүрдүүлж байгаа нь хангалтгүй бөгөөд цаашид зээлийн хэмжээг нэмэгдүүлж, ДНБ-ийн 10 хувьд хүргэх шаардлагатай.

Банк бус санхүүгийн байгууллагуудын иргэд, аж ахуй нэгжид олгож байгаа зээлийн дундаж хүү нь банкны салбартай харьцуулахад 1.5-2.0 дахин их байгаа нь ядуурлыг бууруулах, дунджаас доогуур орлоготой иргэдийг дэмжих гэдгээс илүүтэй иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдээс өндөр хүүтэйгээр орлого олох хандлага илүү ажиглагдаж байна.

Иймд банк бус санхүүгийн байгууллагын тоог хэт нэмэгдүүлэхгүйгээр дүрмийн санг өсгөх, хариуцлагын тогтолцоог сайжруулах, зээлийн хүүгийн түвшинг эдийн засгийн нөхцөл байдал, ядуу иргэдийн амьжиргааны түвшинтэй уялдуулж тогтоох зэрэг өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжид оруулах, бичил санхүүгийн салбарыг сонгодог утгаар нь ядуурлыг бууруулах, бага орлоготой иргэдэд шаардлагатай санхүүгийн үйлчилгээг үзүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна.

4.2. Банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид:

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагыг үйл ажиллагааны төрлөөр нь харуулсан бөгөөд тайланд хугацаанд нийт 395 ББСБ бүртгэлтэй байгаагаас 85.8 хувийг зээлийн үйл ажиллагаа, 34.7 хувийг гадаад валютын арилжаа, факторингийн үйлчилгээ 4.1 хувийг, 6.1 хувийг илтгэлцлийн үйлчилгээ, үлдсэнийг бусад үйл ажиллагаа бүрдүүлж байна.

Хүснэгт-11

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо /давхардсан тоогоор/			
		2014-I		2015-I	
		тоо	хувь	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	289	-	395	-
1	Зээл	242	83.7	339	85.8
2	Гадаад валютын арилжаа эрхэлдэг	111	38.4	137	34.7
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	44	15.2	53	13.4
3	Факторингийн үйлчилгээ	15	5.2	16	4.1
4	Төлбөрийн баталгаа гаргах	10	3.5	10	2.5
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	1.7	6	1.5
6	Итгэлцлийн үйлчилгээ	21	7.3	24	6.1
7	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	0.7	2	0.5
8	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	23	8.0	25	6.3


4.3. Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн үзүүлэлт

Активын үзүүлэлтүүд:

2015 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 395 банк бус санхүүгийн байгууллага нь 515,9 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа ба тайлант хугацааны ДНБ-ний /урьдчилсан гүйцэтгэл/ 11.4 хувийг эзэлж байна.

График-5

Банк бус санхүүгийн байгууллагын актив



Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын хэмжээ 2006 оноос эхлэн өсөн нэмэгдсээр 2014 оны байдлаар 506.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны үеэс 125.7 тэрбум төгрөгөөр буюу 75.2 хувиар өссөн байна. Банк бус санхүүгийн байгууллагын нийт активын хэмжээ өсөхөд иргэд, хуулийн этгээдэд олгосон зээлийн хэмжээний өсөлт гол нөлөөг

үзүүлжээ.2015 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт активын хэмжээ 515.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт активын 96.8 хувийг эргэлтийн хөрөнгө, 3.2 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байна.

График-6



2015 оны 1 дүгээр улирлын нийт активын бүтцийг ангилан харвал мөнгөн хөрөнгийн хэмжээ өмнөх оны үеэс 21.94 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 8.77 хувь, нийт зээл 35.33 хувиар тус тус өсч, харин бусад активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.46 хувиар буурсан үзүүлэлттэй гарчээ.

График-7



Хүснэгт-12

№	Богино хугацаат хөрөнгө оруулалт	ББСБ-ын тоо	Дүн /мян.төг/	Нийт богино хугацаат хөрөнгө оруулалтад эзлэх хувь
1	Арилжааны үнэт цаас	8	94,548.3	0.8
2	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	12	11,405,367.9	99.2


Нийт	20	11,499,916.2	100.0
-------------	-----------	---------------------	--------------

Тайланд хугацаанд банк бус санхүүгийн байгууллагын богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 8.77 хувиар өссөн бөгөөд нийт 18 банк бус санхүүгийн байгууллага “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн хувьцааг худалдан авсан байна. Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 2-т заасан “Таван толгойн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэс-Таван толгой” компанийн хувьцааны 50 хүртэлх хувийг Монгол Улсын иргэн, үндэсний аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх, дотоод, гадаадын хөрөнгийн биржээр арилжаалах талаар дараах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх” шийдвэрийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа болно.

Зээлийн үзүүлэлт

Нийт зээлийн багцын үлдэгдлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 35.3 хувиар нэмэгдсэн байх ба нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээл 1.1 дахин, чанаргүй зээлийн эзлэх хувь 1.0 дахин өссөн байна. Тайлант хугацааны нийт зээлийн үлдэгдлийн 12.2 хувийг валютаар олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График-8



Зээлийн чанарыг өмнөх онуудтай харьцуулахад нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь сүүлийн 5 жилийн дунджаас 2.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд макро эдийн засгийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлт буурсантай холбоотойгоор иргэд, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, орлогын хэмжээнд шууд нөлөө үзүүлж, улмаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн хэмжээнд чанаргүй зээлийн түвшин өсөх шалтгаан болжээ.

4.4. Банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны үзүүлэлт:

Бичил санхүүгийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт-13

№	Үзүүлэлтүүд /байгууллагын бүтэц/	2014-I	2015-I	Өөрчлөлт
1	ББСБ-ын тоо	289	395	106
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	724	830	106

3	Ажиллагсадын тоо	1,433	1,623	190
4	Салбар нэгжийн тоо	85	109	24
5	Харилцагчдын тоо	288,017	405,558	117,541

№	Үзүүлэлтүүд /байгууллагын үйл ажиллагаа тэрбум.төгрөг/	Хүснэгт-14		
		2014-I	2015-I	Өөрчлөлт /хувиар/
1	Нийт олгосон зээл	245,4	332,1	35.33
2	Нийт өөрийн хөрөнгө	250	337,3	34.92
3	Нийт хувьцаат капитал	198,8	262,0	31.79
4	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	22,2	28,4	27.93
5	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл:	96,0	120,8	25.83
	Богино хугацаат	66,5	63,2	-4.96
	Урт хугацаат	29,4	57,5	95.58
8	Төслийн зээлийн санхүүжилт	10,4	13,3	27.88
9	Нийт орлого	33,6	37,0	10.12
10	Нийт зардал	26,0	28,0	7.69
11	Тайлант үеийн цэвэр ашиг	7,5	8,9	18.67

Дээрх хүснэгтэнд 2015 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын үндсэн үзүүлэлтийг харуулсан бөгөөд 2014 оны жилийн эцсийн тоо мэдээлэлтэй харьцуулсан болно.

Байгууллагын бүтцийн үзүүлэлтийн хувьд өмнөх оны үеэс өссөн дүр зураг харагдаж байгаа бөгөөд ББСБ-ын тоо 106, хувьцаа эзэмшигчдийн тоо 106, ажиллагсдын тоо 190, салбар нэгжийн тоо 24, харилцагчдын тоо 117,541-ээр тус тус нэмэгдсэн байна. Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал, төсөв, төлбөрийн тэнцлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хангалтгүй түвшинд хүрч, судлаачдын үзэж байгаагаар 2015 оны жилийн эцэст эдийн засгийн өсөлт 3-4 орчим хувьд хүрч буурах төлөвтэй байгаа бөгөөд улс төрийн тогтворгүй байдал болон томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт түр зогссонтой холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалт огцом буурсан нь үндсэн шалтгаан болж байгаа юм.

Макро эдийн засгийн хүнд нөхцөлд бичил санхүүгийн салбарт банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны ашиг нэмэгдэж, цаашид ч банк бус санхүүгийн байгууллага хүрээгээ улам тэлэх хандлагатай байгаа нь дараах хүчин зүйлсээс нөлөөтэй гэж үзэхээр байна.

- Бага болон дундаж орлоготой иргэдийн зээл авах эрэлт өссөн
- Жижиг дунд бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсэн
- Банкны салбарт чанаргүй зээлийн хэмжээ өсч байгаа нь эрсдэлтэй бүлэгт тооцогдох бага орлоготой иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зээл олгох сонирхлыг бууруулсан
- Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо нэмэгдсэн
- Үйл ажиллагааны зардлаа хэмнэж, ашгийн түвшингээ өсгөсөн банк бус санхүүгийн байгууллагууд хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор орон нутагт салбараа нээж, орон нутгийн иргэдэд үйлчилгээгээ хүргэх болсон.

4.5. Банк бус санхүүгийн байгууллагын зохистой харьцааны үзүүлэлт

Тайлант хугацаанд Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон шалгуур үзүүлэлтийг салбарын хувьд хангаж байгаа боловч банк бус санхүүгийн байгууллагуудын зохистой харьцааг хангаж буй байдал дараах байдалтай байна.

Хүснэгт-15

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан	160	40.5%
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй	159	40.3%
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй	47	11.9%
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй	15	3.8%
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй	13	3.3%
6	5 ба түүнээс дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй	1	0.3%
	Нийт	378	100.0%

Бичил санхүүгийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт хийх сонирхол нэмэгдэж, банк бус санхүүгийн байгууллагуудын тоо нэмэгдэж байгаа нь дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож байгаа бөгөөд үүнийг дагаад банк бус санхүүгийн байгууллагуудын чанаргүй зээлийн хэмжээ өссөн.

4.6. Хадгаламж зээлийн хоршооны өнөөгийн байдал:

Хадгаламж зээлийн хоршоодын хувьд тайлант хугацаанд ДНБ-д харьцуулсан нийт активын хувь 1.90 хувьтай байгаа бөгөөд энэхүү өсөлтөд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй хадгаламж зээлийн хоршоодын гишүүдийн тоо 4,184-өөр нэмэгдсэн нь нийт активын өсөлтөд нөлөөлсөн ба нийт активын хэмжээ 7,98 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд хүргэсэн.

Цэвэр зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,251 тэрбум төгрөгөөр буюу 15.0 хувиар өссөн бол чанаргүй зээлийн үлдэгдэл 0,320 тэрбум төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн байна. Хадгаламж зээлийн хоршоодын нийт олгосон зээлийн хэмжээ ДНБ-тэй харьцуулахад 1.58 хувь, нийт хадгаламжийн хэмжээ ДНБ-тэй харьцуулахад 1.25 хувьтай тус тус байна.

Хадгаламж зээлийн хоршоодын ашигт ажиллагааны хувьд 2015 оны 1 дүгээр улирлын байдлаар 109 ХЗХ 1,143 тэрбум төгрөгийн ашигтай, 29 ХЗХ ашиг, алдагдалгүй, 66 ХЗХ 177,806.2 мянган төгрөгийн алдагдалтай тус тус ажиллаж салбарын хэмжээнд нийт 483,083.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба салбарын активын өгөөж 4.9 хувьтай гарсан бөгөөд салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 100,449.9 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант үеийн ашгийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 388,622.5 мянган төгрөгөөр буурсан нь шинээр 49 ХЗХ байгуулагдан үйл ажиллагааны зардал гарсан болон хадгаламжийн хүүгийн зардал, зээлийн эрсдэлийн зардал өндөр гарсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль 2011 онд батлагдаад удаагүй байгаа бөгөөд хадгаламж зээлийн хоршоодын гишүүдийн хадгаламжийг даатгуулах нь аливаа эрсдэлээс

хамгаалах, хөрөнгөө хадгалуулагчдыг хамгаалах тул энэ талаар төрийн болон бусад байгууллагын чиг үүргийг тодорхой болгох, цаашид холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулах шаардлагатай.

2014 оны жилийн эцсийн байдлаар Хорооны 2014 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д тусгагдсан шалгуур үзүүлэлтээс “Хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээ”-г хангаагүй 152, “Нийт хөрөнгөд эзлэх активын зохистой харьцаа”-г хангаагүй 105 ХЗХ-д байсан ба 2015 оны 1 дүгээр улирлын байдлаар шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан 44 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 21.5 хувийг эзэлж байгаа бөгөөд дээрх шалгуур үзүүлэлтийн дүн нь эрсдэлийг тодорхой хэмжээгээр өсөхөд нөлөө үзүүлж байгаа тул гишүүдийн хадгаламжийг даатгуулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна.

4.7. Хадгаламж зээлийн хоршоод, тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүд:

Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаа эрхлэгчид, гишүүдийн тоо, санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдлаар хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт-16

№	Үндсэн үзүүлэлтүүд /мян.төг/	2014 оны I	2015 оны I	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	140	207	67	47.9
2	Гишүүдийн тоо	27,030	32,778	5,748	21.3
3	Нийт актив	75,985,971.0	85,768,698.0	9,782,727.0	12.9
4	Нийт зээлийн үлдэгдэл	61,732,910.0	71,582,329.0	9,849,419.0	16.0
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,645,059.0	1,965,428.0	320,369.0	19.5
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	52,161,375.0	56,663,428.0	4,502,053.0	8.6
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	9,841,119.0	10,092,303.0	251,184.0	2.6
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	6,737,759.0	8,049,666.0	1,311,907.0	19.5
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	1,443,585.0	3,750,482.0	2,306,897.0	159.8
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	465,598.0	2,329,003.0	1,863,405.0	400.2
11	Нийт орлого	4,524,473.0	5,045,748.0	521,275.0	11.5
12	Нийт зардал	3,652,249.0	4,562,665.0	910,416.0	24.9
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	872,224.0	483,083.0	-389,141.0	-44.6

Өмнөх оны мөн үеэс нийт ХЗХ-дын гишүүдийн тоо 21 хувиар, нийт актив 13 хувиар тус тус өссөн байна. Мөн нийт зээл болон татан төвлөрүүлсэн хадгаламжийн банкны салбарт эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өссөн байна. Нийт актив 9,8 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд гишүүдийн хадгаламж 4,5 тэрбум төгрөгөөр, бусдаас авсан зээлийн эх үүсвэр 4,1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 17/16 дугаар тогтоолоор "Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"

өссөн байна. Тайлант улиралд ХЗХ-дын нийт зээлийн багц 71,58 тэрбум төгрөг байгаа нь активын 83.0 хувийг, цэвэр зээл 70,07 тэрбум төгрөг буюу активын 82.0 хувийг тус тус эзэлж байна.

Хадгаламж зээлийн хоршоодын хадгаламжийн үзүүлэлтүүд:

График-12



Тайлант хугацаанд татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 56,6 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 66.1 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 55,3 тэрбум төгрөг буюу 97.7 хувь нь 10,375 гишүүний хугацаатай хадгаламж байгаа бол 1,308 тэрбум төгрөг буюу 2.3 хувь нь 3,824 гишүүний хугацаагүй хадгаламж байна.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 12 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 48,340,561.8 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламжийн 55.8 хувийг эзэлж байна.

График-13



Тайлант хугацаанд 109 ХЗХ 1,143,973.1 мянган төгрөгийн ашигтай, 29 ХЗХ ашиг, алдагдалгүй, 66 ХЗХ 177,806.2 мянган төгрөгийн алдагдалтай тус тус ажиллаж, салбарын хэмжээнд нийт 483,083.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан. Салбарын активын өгөөж 4.9

хувьтай гарсан бөгөөд салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 100,449.9 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсын санхүүгийн салбар сүүлийн 5 жилийн хугацаанд хурдтай өсч байгаа бөгөөд уул уурхайн салбараас хамааралтай эдийн засагтай улсын хувьд тухайн салбарт оруулах гадаадын хөрөнгө оруулалт буурах, дэлхийн түүхий эдийн ханш унах зэрэг гадаад хүчинзүйлсээс макро эдийн засгийн тогтвортой байдал хийгээд эдийн засгийн өсөлтөд шууд хамаарч байдаг.

Аливаа улсын санхүүгийн систем нь төлбөр тооцоо гүйцэтгэх, санхүүгийн зуучлал үзүүлэх, зах зээл дээр хөрвөх чадварыг хангах, эрсдэлийг удирдах зэрэг эдийн засгаа дэмжих чухал үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Монгол Улсын хувьд банк болон банкнаас бусад санхүүгийн салбарын уялдаа холбоог сайжруулах, банк давамгайлсан тогтолцоог өөрчлөн богино хугацааны эх үүсвэрээс илүүтэй урт хугацааны санхүүжилтийг үнэт цаасны зах зээл, даатгалын салбараар дамжуулан хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашид ганц тулгуурт санхүүгийн тогтолцооноос олон тулгуурт санхүүгийн тогтолцоонд шилжих, нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, макро эдийн засгийн өсөлтийг дэмжих шаардлагатай байна.

Монгол Улсын санхүүгийн салбарын 95 орчим хувийг банкны салбар эзэлж байгаа нь банкнаас бусад санхүүгийн салбарын үйлчилгээний хүртээмжийг бууруулж, эдийн засгийн өсөлт, үр өгөөжийг нэмэгдүүлэх урт хугацааны төслийг санхүүжүүлэх бололцоог бууруулж байна.

V БҮЛЭГ:ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨДҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

5.1. Үнэт цаасны зах зээл:

Манай орны эдийн засагт банкны салбарын зуучлалын үүрэг оролцоо үнэт цаасны зуучлалаас илүү хөгжсөн тул хөрөнгө оруулалтын урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай, үнэт цаасны зах зээлийн эдийн засгийн бодит өсөлтөд үзүүлэх нөлөөлөл сул байна.

Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг тооцох, түүнд нөлөөлөгч макро эдийн засгийн болон бодлогын хувьсагчуудын харилцан хамаарлыг тогтоох чиглэлээр үнэт цаасны зах зээлийг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагын хувьд нарийвчилсан судалгаа, шинжилгээ, эконометрикийн арга, аргачлалыг ашиглан урт хугацааны хөгжлийн бодлогоо тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөгжингүй орнуудын туршлагаас харахад зах зээлийн үнэлгээний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 100-аас дээш хувийг эзэлдэг ба энэ нь үнэт цаасны зах зээлд эргэлдэж буй капиталын хэмжээ нь нийт эдийн засгийн гарцын хэмжээнээс өндөр болохыг илтгэж, урт хугацааны эдийн засгийн өсөлтийг голлон тодорхойлогч болдог.

Үнэт цаасны зах зээл нь урт хугацаандаа эдийн засгийн өсөлтөд дараах 3 үндсэн сувгаар дамжин нөлөөлдөг.

- Үнэт цаасны зуучлалаар дамжуулан сул чөлөөтэй хуримтлалыг үр ашигтай хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтэд хуваарилдаг;
- Хөрөнгө оруулагчийн хувьд үр ашигтай тодорхой төслийг санхүүжүүлж ашиг олох ба үнэт цаас гаргагчийн хувьд өртөг багатай хөрөнгийн эх үүсвэрийг татахад гарч буй үйлдлийн болон мэдээллийн зардлуудыг бууруулдаг;
- Хөрөнгө оруулагчдад эрсдлээ оновчтой удирдах замаар хөрөнгөө үр ашигтай хуваарилах боломжийг олгодог.

Үнэт цаасны зах зээлийн хөгжил болон эдийн засгийн өсөлт дараах 3 хэлбэрээр харилцан хамааралтай:

- Үнэт цаасны зах зээлийн хөгжил нь эдийн засгийн өсөлтийн учир шалтгаан;
- Эдийн засгийн өсөлт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжигч;
- Үнэт цаасны зах зээлийн хөгжил ба эдийн засгийн өсөлт нь харилцан нэг нэгнийхээ учир шалтгаан.

Өмнө нь хийгдэж байсан судалгааны үр дүнгээс манай орны эдийн засгийн өсөлт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжигч учир шалтгаан болдог гэсэн дүгнэлтэд хүрсэн бөгөөд цаашид судалгааны ажлуудыг тогтмол үргэлжлүүлж, шинэчлэн тооцоолж байх нь зүйтэй. Одоогийн байдлаар Хорооноос үнэт цаасны зах зээлийн хөгжилд нөлөөлөх макро эдийн засгийн болон институциональ хүчин зүйлсийн шинжилгээ, мөнгөний болон сангийн бодлогын харилцан хамаарлыг эконометрикийн арга, аргачлалаар үнэлгээ хийж, цаашдын таамаглалыг боловсруулах ажлууд хийгдэж байна.

5.2. Даатгалын салбар:

Даатгалын салбарын зуучлалын хөгжил нь эдийн засгийн өсөлтөд дор үзүүлсэн 4 үндсэн сувгаар нөлөөлдөг:

- Даатгалын салбар нь бизнесийн орчин дахь тодорхойгүй байдлыг арилгаж, хөрөнгө оруулалт, инноваци, санаачлагыг дэмжсэнээр эдийн засгийн өсөлтийг дэмжинэ;
- Урт хугацааны арилжааны даатгал нь улсын нийгмийн даатгалын салбарын нэмэлт тогтолцоо болж хөгжсөнөөр урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмжинэ;
- Арилжааны даатгал нь өөрийн нөөц хөрөнгөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчийн үүднээс оролцож, зах зээлийг идэвхжүүлснээр санхүүгийн зах зээлийн хөгжилд нөлөөлнө;
- Даатгалын салбар нь бизнесийн салбарт эрсдлийн удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлснээр системийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, эдийн засгийн өсөлтөд дам нөлөөлдөг.

Даатгалын салбар болон макро, микро эдийн засаг, нийгмийн салбарууднь бие биедээ дээрх үндсэн сувгуудаар дамжуулан харилцан шууд болон дам байдлаар нөлөөлдөг.

Хорооны зүгээс даатгалын салбарын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл, эргээд эдийн засаг, нийгэм, зах зээлийн бүтэц, хүн ам зүйн хүчин зүйлсийн даатгалын салбарт үзүүлэх нөлөөллийг эконометрикийн загвараар тооцох, хөгжлийн хандлагыг тодорхойлох ажлыг хэрэгжүүлж байна.

5.3. Бичил санхүүгийн салбар:

Бичил санхүү нь улс орны санхүүгийн систем рүү өрхийн санхүүгийн хэрэгцээг нэгтгэж оруулдаг бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөө үзүүлдэг. Мөн бичил санхүүгийн сувгийн нөлөөлөл нь орлогын тэгш бус байдал, ядуурлыг бууруулдаг байна.

Бичил санхүүгийн салбарын эдийн засагт нөлөөлөх хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Санхүүгийн тогтвортой бичил санхүүгийн байгууллагууд нь зах зээлийг тэлж өргөжүүлснээр санхүүгийн хөгжлийг дэмждэг;
- Бичил санхүү нь хөгжсөн болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын аль алинд нь санхүүгийн зах зээлийн хөгжлийн хугацааг хурдасгадаг;
- Бичил санхүү нь эдийн засагт тулгардаг тодорхой хязгаарлалтыг бууруулснаар дотоодын санхүүгийн шинэчлэлд дэмжлэг болдог;
- Бичил санхүү нь өрхийн санхүүгийн зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлдэг.

Нөгөө талаас бичил санхүү нь орлогын тэгш бус байдал, ядуурлыг бууруулж байгаа нь эргээд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж байгаа бөгөөд энэ нь шууд бус замаар эдийн засгийн бүтцийг тодорхойлоод зогсохгүй, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлдэг.

Хорооноос бичил санхүүгийн салбарын эдийн засгийн өсөлт, банкны зээл, хадгаламжийн хүүгийн түвшинд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийн харилцан хамаарлыг тогтоох чиглэлээр системийн хэмжээний загварыг боловсруулахаар ажиллаж байна.

VI БҮЛЭГ: ҮНЭТ ЦААС, ДААТГАЛ, БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРТ ЦААШИДХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

6.1. Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр:

Хорооноос үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг өсгөж, урт хугацаанд эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийг дээшлүүлэх урт хугацааны “Санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэл хугацааны шинэчлэл, хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг боловсруулаад байна.

Хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлснээр дунд хугацаанд эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, чанаржуулах, дэд бүтцийн оновчтой тогтолцоог бүрдүүлэн, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг зах зээлд татан оролцуулах, санхүүгийн зах зээлийн нэгдсэн хяналт хэрэгжих боломж бүрдэнэ. Мөн урт хугацаанд олон нийтийн санхүүгийн болон хөрөнгө оруулалтын боловсрол дээшлэх, хөгжлийн үзүүлэлтүүдийн бодит өсөлт хангагдах, бүс нутгийн интеграцид нэгдэх, эдийн засгийн өсөлтөд үнэт цаасны зах зээлийн зуучлалын үзүүлэх нөлөөлөл нэмэгдэнэ.

Урт хугацааны хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд Хороо зохицуулалт, хяналтын эрх зүйн актуудыг шинэчлэн, бодлогын арга механизмын хэрэгсэл хэлбэрээр ашиглах шаардлагатай. Ингэснээр уян хатан зохицуулалтын орчноор дамжуулан урт хугацааны стратегид туссан зорилтуудыг төлөвлөсөн цаг хугацаанд бүрэн хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

6.2. Даатгалын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр:

Даатгалын салбарт бодлогын чиглэлээр Хорооны үйл ажиллагааны стратегид дор дурдсан асуудлыг тусган хэрэгжүүлнэ. Үүнд:

- УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-т заасан “Үндэсний давхар даатгалын компанийг” байгуулах ажлыг Сангийн яамтай хамтран хэрэгжүүлэх;
- Албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүнийг бий болгох чиглэлээр төрөлжсөн хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барих;
- Банк, түүний охин, хараат компаниудын даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;
- Даатгалын салбарын мэргэжлийн холбоодыг өөрийгөө зохицуулах байгууллагын хэлбэрт оруулж, Хорооны зарим хяналт, шалгалт, сургалтын чиг үүргийг үе шаттайгаар шилжүүлэх;
- Улсын нийгмийн даатгалын тогтолцоо урт хугацааны даатгалын хэлбэрээр хөгжүүлэх чиглэлээр Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын яамтай хамтран үндэсний нийгмийн хамгаалалын бодлого, хөтөлбөрт тусгуулах;
- Даатгалын салбарын газар дээрх болон зайны хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоонд шилжүүлэх, салбарын нэгдсэн мэдээллийн санг бий болгох;
- Даатгалын салбарын хөгжлийг идэвхжүүлэх чиглэлээр Хувь хүний орлогын албан татварын болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалтыг оруулах талаар Сангийн яамтай хамтран ажиллах;
- Даатгалын компаниудыг өөрийн нөөц сангийн хөрөнгөд тулгуурлан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагч болгоход чиглүүлэх, үнэт цаасны зах зээлд тулгуурласан шинэ бүтээгдхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд

зохицуулалтын оновчтой орчинг бий болгох чиглэлээр хөрөнгийн биржтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх;

- Даатгалын салбарын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл, тус салбарт үзүүлэх макро эдийн засаг, хүн ам зүй, нийгэм, газар зүйн хүчин зүйлсийн нөлөөллийг тооцсон системийн хэмжээний хөгжлийн загварчлалыг бий болгох, судалгааны үр дүнд тулгуурласан мөчлөг сөрсөн бодлого боловсруулах чиглэлд судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх;
- Уул уурхайн болон аж үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй гадаадын хөрөнгө оруулалттай томоохон компаниудын техник, тоног төхөөрөмжийг Монгол Улсын даатгалын компаниудаар даатгуулах чиглэлээр албадлагын зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид оруулах.

6.3. Нэгдсэн бодлого, зохицуулалтын чиглэлээр:

Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарын 2015 оны 1 дүгээр улирлын статистик үзүүлэлтүүд болон салбаруудын тулгамдсан асуудал, дүгнэлтүүдэд тулгуурлан дараах нэгдсэн дүгнэлтийг хийж байна.

- Санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны хөгжил, шинэчлэлийн хөтөлбөрийг УИХ-аар батлуулж, Хорооны үйл ажиллагааны стратеги болон ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх;
- Хорооноос албан журмын даатгалыг төрөлжүүлэх чиглэлээр холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах;
- Нийгмийн хамгаалал, халамжийн хөрөнгийг хувийн даатгалын байгууллагаар дамжуулан хуримтлалын, урт хугацааны даатгалын бүтээгдэхүүн хэлбэрээр зорилтот бүлэгт хүргэх;
- Бичил санхүүгийн салбарыг олон улсад тогтсон ажлын байр нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах зорилгоор өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн зээлийн санхүүжилтийн тогтолцоо хэлбэрээр хөгжүүлэх;
- Үнэт цаасны зах зээлийг мөн хөгжлийн хөтөлбөрийн эрэлт, нийлүүлэлт, дэд бүтцийн уялдаа холбоо, олон нийтийн санхүүгийн болон хөрөнгө оруулалтын боловсролыг дээшлүүлэх үндсэн чиглэлүүдэд заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар урт хугацааны хөгжлийг хангах;
- Хорооны зохицуулалтын дүрэм, журмуудыг хөгжлийн хөтөлбөрт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх чиглэлд бодлогын арга хэрэгсэл утгаар нь шинэчлэх;
- Санхүүгийн зах зээлийн нэгдсэн хяналт, шалгалтыг Хорооноос хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, эрсдэлд суурилсан хяналтыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Өнөөгийн үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн төрийн зохицуулалт, хяналт нь зах зээлийн гарц буюу хөгжлийн үзүүлэлтүүдэд нөлөөлөх нөлөөлөл сул, эрсдэлд суурилсан хяналт бус, харин батлагдсан дүрэм, журамд суурилсан төлөвлөгөөт шинжийг өөртөө агуулж байна. Дүрэм, журамд суурилсан хяналт, шалгалтын сул тал нь цаг хугацааны хоцролтоор илэрдэг.

Хорооны зохицуулалтад хамрагддаг үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбаруудын зуучлалын хөгжил өөрийн сувгуудаар дамжин эдийн засгийн тогтвортой өсөлтийг урт хугацаанд хангагч үндсэн хэрэгслүүд болдог бөгөөд тэдгээрийн хоорондын харилцан хамаарлыг илрүүлэх чиглэлээр 2015 онд багтаан нэгдсэн бодлого, зохицуулалтын эконометрик загварчлалыг боловсруулах шаардлагатай.

Япон улсын Санхүүгийн үйлчилгээний агентлаг /Financial service agency/, Англи улсын CRA international байгууллагууд нь санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын орчин, түүний зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд үзүүлэх нөлөөллийг судлаад, “Үр ашигтай зохицуулалтын бодлого, түүнийг хэрэгжүүлэх дамжуулах механизм” гэх шинэ загварчлалыг бий болгосон байна.

Энэхүү загварчлал нь санхүүгийн зах зээлийг зохицуулах төрийн байгууллага нь зохицуулалт, хяналтын арга хэрэгслүүдээр дамжуулан үнэт цаас гаргагч, мэргэжлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаа, хөрөнгө оруулагч, харилцагчийн зах зээлд хандах хандлагад нөлөөлөх замаар гарцын буюу зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг жолоодох боломжтой гэж томъёолдог.

Эдийн засгийн өсөлтийг хангах, нийт эрэлт, нийлүүлэлтүүдийг тэнцвэржүүлэх зорилгоор төрөөс мөнгөний болон сангийн бодлогын үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаас батлуулан Монголбанк, Сангийн яам өөрийн бодлогын арга хэрэгслүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг. Түүнчлэн үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарыг зохицуулах байгууллагаас өөрийн бодлого, бодлогын хэрэгслүүдийг хэрхэн зөв оновчтой тодорхойлж, хэрхэн хэрэгжүүлснээс зах зээлийн гарц буюу хөгжлийн үзүүлэлтэд шууд болон дам нөлөө үзүүлэх замаар өсгөх боломж бүрдэнэ.

Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл, байдлаас харахад салбаруудын хөгжлийг зайлшгүй нэгдсэн нэг бодлогын хүрээнд нэгтгэн зангидах, цаашилбал нэгдсэн хяналт, шалгалтыг Хорооноос дагнан хэрэгжүүлэх шаардлага тулгаараад байгаа нь харагдаж байна.

Салбаруудын бодлогыг нэгдсэн нэг байдлаар боловсруулан хэрэгжүүлснээр төрөөс баримталж буй мөнгөний болон сангийн бодлогод Хорооны бодлого, хөтөлбөрийг нийцүүлэн шинэчлэх, тэдгээрт тусгуулах боломж бүрдэх бөгөөд санхүүгийн зах зээлийн өсөлтөд шокын нөлөөлөл үзүүлэх боломж, бодлогын арга хэмжээнүүдийн өнөөгийн нөхцөл, байдалд тулгуурлан цаг тухайд шинэчлэх боломж бүрдэх юм.

--oOo--